

ОРОС-МОНГОЛЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ХӨГЖЛИЙН ЧИГЛЭЛ



Банкуудын баримтлаж буй бодлого

Банкууд анхнаасаа, нөхцөл байдал үүссэн цаг үеэс, ОХУ-тай холбоотойгоор холбогдох газар, хэлтсүүд ажлын хэсэг байгуулж, тус бүрнээ Эрсдэлийн дүгнэлтийг гаргаж, дүгнэлтийг цаг тухайд нь шинэчилж, дүгнэлтийн үр дүнд ОХУ-тай холбоотой эрсдэлийг ХҮЛЭЭН АВЧ (ACCEPT), DE-RISKING хийлгүйгээр, эрсдэлийг БУУРУУЛАХ (MITIGATE) хийх арга хэмжээг авч ажиллаж байна.


Банкуудаас авч буй арга хэмжээнүүд

ОХУ-руу гүйлгээ дамжуулж өгч буй банкнуудын шаардлагыг хангаж, de-risking-д өртөхгүй байхын тулд ОХУ-руу гарч буй гүйлгээ бүрийг бодит цагийн горимд хянаж, тодруулж, мэдээллийг шалгаж, зөвшөөрөл өгч гаргаж байна. Энэ нь Комплайнсын хэлтсийн ачааллыг нэмэгдүүлж байгаа.

Банкны Олон улсын банкны хариуцсан нэгжээс ОХУ-руу төлбөр тооцоо дамжуулах боломжийг нэмэгдүүлэх арга хэмжээг тасралтгүй авч ажиллаж байна

Банк өөрөө хоригт орох, de-risking-д өртөх магадлалтай хэдий ч нэн шаардлагатай бүтээгдэхүүн, үйлчилгээтэй холбоотой харилцагчдын жагсаалтыг гаргаж, төлбөр тооцоог чөлөөтэй дамжуулж өгч байна

ОХУ-руу гарч буй юанийн гүйлгээ бүрд БНХАУ-ын банкнуудаас асуулга ирж байгаа ба хариуг цаг тухайд нь хүргүүлж байна.



Салбар, тооцооны төвүүд рүү тогтмол зөвлөмж хүргүүлж байна

Хориг жагсаалтын мэдээллийг тогтмол шинэчилж, банкны удирдлага болон холбогдох газар хэлтсүүдийг цаг үеийн-хориг арга хэмжээний мэдээллээр тогтмол хангаж ажиллаж байна.

2 удаагийн давтамжтайгаар яаралтай горимоор Удирдлагын хороонд танилцуулж шийдвэрлүүлсэн.

Эрсдэлийн удирдлагын газар Эрсдэлийн үнэлгээ хийж, холбогдох газар, хэлтсүүдэд зөвлөмж хүргүүлэв. Зөвлөмжийн биелэлтийг эргэж хянав.

Тулгарч буй асуудал – Хүндрэл, бэрхшээл

ОХУ-ЫН БАНКНУУДАД БАЙРШИХ НОСТРО ДАНСНЫ ЗУЗААТГАЛ

ОХУ-ын банкнууд дээрх ностро дансыг зузаатгахад тулгарч буй асуудлуудыг шийдэх боломжит гарц нь БНХАУ-ын банкуудаар дамжуулан, зузаатгалын гүйлгээг хийх юм. Одоогийн байдлаар зарим нэг зузаатгалын гүйлгээг БНХАУ-ын 1-2 банкаар дамжуулан хийж байгаа боловч тус банк нь тодорхой байр сууриа илэрхийлээгүй байх ба гүйлгээнүүд тодорхой хугацаагаар саатаж байна.

ЦАГ ХУГАЦАА АЛДАХ

Ностро данс нээх гэрээний төсөл дээр санал солилцох үйл ажиллагаанд хамгийн их хугацаа зарцуулагдаж байгаа бөгөөд ОХУ руу илгээгдэх бичиг баримт 2 долоо хоногоос сарын хооронд ОХУ-ын корреспондент банкад хүрч байгаа нь ОХУ-ын банк дээр данс нээх үйл ажиллагааг тодорхой хугацаагаар удаашруулж байгаа юм.

ТОДОРХОЙГҮЙ БАЙДАЛ

Fitch, Moddy's зэрэг олон улсын үнэлгээний байгууллагууд ОХУ-ын 27 банкнаас WITHDRAW хийв. Ингэснээр ОХУ-ын банкнуудын зээлжих зэрэглэлийн үнэлгээ тодорхойгүй болж байна. Өөрөөр хэлбэл default зарласан/зарлах гэж байгаа банктай ч хамтран ажиллаж байгаагаа мэдэхгүй байх нөхцөл үүсээд байна.

ХОРИГ БА DE-RISKING

Банк гүйлгээг дамжуулснаараа TRANSKAPITAL банктай адил шалтгаанаар хоригт орох болон корреспондент банкнууд банкнийг ОХУ-руу гүйлгээ хийж байгаагаас улбаалан DE-RISKING хийх.

САНАЛ ГОМДОЛ

Бусад банкнууд ОХУ-руу гүйлгээ хийхгүй байхад ХХБ гүйлгээг хийж өгч байж харилцагчийн гомдлын бай болж байна. Ихэнх тохиолдолд, хэвийн нөхцөлд ч хийх боломжгүй гүйлгээн дээр харилцагчид ОХУ-тай холбоотойгоор хэт эмзэг хандаж гомдол гаргаж байна.

РУБЛИЙН БЭЛЭН ВАЛЮТЫН НӨӨЦИЙН ХОМСДОЛ

Нөхцөл байдал хүндрэхээс өмнө ХХБ нь Sber bank болон Transkapital bank-тай арилжаа хийж, рубль худалдаж авдаг байсан бол тус банкууд нь хориг жагсаалтад орсноор рубль худалдаж авах боломжгүй болсон.



Шийдэл, гарц гаргалгаанууд

ОХУ-н ностро дансуудаа цэнэглэх боломжийг нэмэгдүүлэх

Олон улсын арилжааны платформоос рубль авах боломжоор хангах

Гуравдагч орны банкны давхар баталгаатайгаар аккредитив, баталгаа нээх

Рублийн санхүүжилтийн боломжийг нэмэгдүүлэх

ОХУ-д байрших томоохон санхүүгийн институциудын хамтын ажиллагааг нэмэгдүүлэх

**АНХААРАЛ ХАНДУУЛСАНД
БАЯРЛАЛАА!**

